



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.04.23 № 20

Гашуунсухайт-Ганцмод боомтын
хил дамнасан төмөр замын
бүтээн байгуулалтын
гэрээ хэлэлцээрийн талаар

Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолыг баталсан.

Дээрх тогтоолд үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-т 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан байна.

Уг хэлэлцээрийн хүрээнд хил дамнасан төмөр замыг хамтран барих, аж ахуйн нэгж хооронд нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ байгуулах, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд холбогдох гэрээнүүдийг байгуулсан боловч эдгээрийг олон нийтэд ил тод байдлаар нийтлээгүй, танилцах боломж хязгаарлагдмал байгаа талаар иргэдээс өргөдөл, гомдол ирүүлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн...” гэж тус тус заасны дагуу байгалийн баялаг ард түмний мэдэлд байж, төрийн нийтийн өмчид хамаарах бөгөөд түүний ашиглалт нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн, ил тод, хяналттай байх зарчмыг тогтоосон.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

1. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой гэрээ, аж ахуйн нэгж хооронд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээг нууцалсан эсэх, хэрэв нууцалсан бол түүний шалтгаан, үндэслэл, мөн ямар хууль, эрх зүйн актад үндэслэн, ямар ангилалд хамааруулан нууцын

